**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөөвөр хөгжил” ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2026/013/НА-СТА-ОНӨҮГ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дорнод аймаг<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br>Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ........................................................................3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН..................................................................5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.............**Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН.................................................**Error! Bookmark not defined.**
4.1 Ерөнхий зүйл .....................................................**Error! Bookmark not defined.**
4.2 Материаллаг байдал..........................................**Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал **Error! Bookmark not defined.**
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .........**Error! Bookmark not defined.**
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн...........**Error! Bookmark not defined.**
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..**Error! Bookmark not defined.**
4.5.1 Завсрын аудитын талаар................................**Error! Bookmark not defined.**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.............**Error! Bookmark not defined.**
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..........................................................................................8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.................................9

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ААТҮГ | Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

"ХӨӨВӨР ХӨГЖИЛ" ОНӨҮГ-ЫН
ДАРГА Ц.ДУЛАМСҮРЭН ТАНАА

2026.03.12 № 351

танай ___________-ны № ______________-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хөөвөр хөгжил" ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын удирдлага нь дээд шатны захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулсан ба гэрээг дүгнээгүй байхад хагас, бүтэн жилээр 150 хувийн урамшуулал 2,454.0 мянган төгрөгийг олгосон, Нягтлан бодогчид орон нутгийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл нийт 7,173.0 мянган төгрөгийг олгосон нийт 9,627.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага нь тасралтгүй үйл ажиллагаа явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудлууд**

Тус байгууллага нь зорилтот түвшний гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлалдаггүй, тайлант хугацаанд ашигтай ажиллах зорилт тавьдаггүй, төсөвт байгууллагатай адилаар төсөв батлалдаг, өөрийн үйл ажиллагааны орлогыг 49,000.0 мянган төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 48,959.8 мянган төгрөгийн орлого олж, орлогын төлөвлөгөө 100 хувьтай биелсэн байна.

2126050130

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 8 тусгай ажил, үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 87.5 хувиар тайлагнасныг Сумын засаг даргын тамгын газраас дүгнээгүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Хөрөнгө | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 2,496,089.77 | 10,682,083.61 |
| 1.1.2 | Дансны авлага | - | - |
| 1.1.6 | Бараа материал | - | 1,411,500.00 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 2,496,089.77 | 12,093,583.61 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 2,100,072,015.72 | 2,566,896,415.15 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | - | - |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 2,100,072,015.72 | 2,566,896,415.15 |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,102,568,105.49** | **2,578,989,998.76** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | | |
| 2.1.1.3 | Татварын өр | | |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | | |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | | |
| 2.3 | Өмч | | |
| 2.3.1 | төрийн | | |
| 2.3.2 | хувийн | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 2,102,568,105.50 | 2,578,989,998.76 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 2,102,568,105.50 | 2,578,989,998.76 |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **2,102,568,105.50** | **2,578,989,998.76** |

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 54,100,502.00 | 48,959,763.00 |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | - |
| 3 | Нийт ашиг ( алдагдал) | - | - |
| 4 | Түрээсийн орлого | - | - |
| 5 | Хүүний орлого | - | - |
| 6 | Ногдол ашгийн орлого | - | - |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| 8 | Бусад орлого | 1,019,381,315.00 | 752,888,600.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 195,224,499.35 | 232,146,690.67 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 67,233,109.62 | 79,613,234.41 |
| 11 | Санхүүгийн зардал | - | - |
| 12 | Бусад зардал | - | 13,666,544.66 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | (175,534,101.00) | - |

| | | | |
|---|---|---|---|
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| 17 | Бусад ашиг ( алдагдал) | - | - |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **635,490,107.03** | **476,421,893.26** |
| 19 | Орлогын татварын зардал | - | - |
| **20** | **Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | **635,490,107.03** | **476,421,893.26** |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал) | 634,490,107.03 | 476,421,893.26 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | - |
| 24 | Нийт дэлгэрэнгүй орлогын дүн | 635,490,107.03 | 476,421,893.26 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

(төгрөгөөр)

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| **1** | 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | - | 1,467,077,998.47 | 1,467,077,998.47 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - |
| **3** | Залруулсан үлдэгдэл | - | 1,467,077,998.47 | 1,467,077,998.47 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | 635,490,107.03 | 635,490,107.03 |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - |
| **9** | 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | - | 2,102,568,105.50 | 2,102,568,105.50 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - |
| **11** | Залруулсан үлдэгдэл | - | 2,102,568,105.50 | 2,102,568,105.50 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | 476,421,893.26 | 476,421,893.26 |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - |
| 15 | Зарласан ногдол ашиг | - | - | - |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - |
| **17** | **2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **-** | **2,578,989,998.76** | **2,578,989,998.76** |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн | 129,540,502.00 | 124,272,763.00 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 129,540,502.00 | 124,272,763.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | - |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | - | - |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 137,337,581.14 | 116,086,769.16 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 46,372,995.00 | 60,059,449.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 12,085,718.52 | 14,243,555.41 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 43,261,300.00 | 5,458,000.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардал төлсөн | - | 6,226,259.09 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 20,403,247.00 | 11,146,050.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 4,474,064.15 | 5,655,061.00 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | - | - |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 10,740,256.47 | 13,298,394.66 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (7,797,079.14) | 8,185,993.84 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн | - | - |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | - | - |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн | - | - |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 3 | Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн | - | - |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн | - | - |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | - |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | - | - |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 4 | Валютын ханшийн зөрүү | - | - |
| 4.1 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (7,797,079.14) | 8,185,993.84 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 10,293,168.91 | 2,496,089.77 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,496,089.77 | 10,682,083.61 |

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2024 оны гүйцэтгэл | Зөрүү | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| Татаас санхүүжилт | | 47,996,000.00 | 47,996,000.00 | - | 100.0 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 54,100,502.00 | 49,000,000.00 | 48,959,763.00 | (40,237.00) | 99.9 |
| Бусад орлого | 1,019,381,315.00 | 38,252,000.00 | 709,284,100.00 | 671,032,100.00 | 1,854.2 |
| **НИЙТ ОРЛОГЫН ДҮН** | **1,073,481,817.00** | **135,248,000.00** | **806,239,863.00** | **670,991,863.00** | 596.1 |
| Цалин хөлс | 46,372,995.00 | 47,996,000.00 | 60,059,449.00 | 12,063,449.00 | 125.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Байгууллага НДШ зардал | 12,085,718.52 | - | 14,243,555.41 | 14,243,555.41 | |
| Байрны түрээс | - | - | - | - | |
| Хангамжийн бараа материалын зардал | 63,664,547.00 | 33,330,000.00 | 16,604,050.00 | (16,725,950.00) | 49.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | - | 860,000.00 | - | (860,000.00) | - |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 15,214,320.62 | 53,062,000.00 | 25,179,714.75 | (27,882,285.25) | 47.5 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассан гарз | 175,534,101.00 | - | - | - | |
| Элэгдлийн зардал | 125,120,027.83 | - | 213,731,200.6 | 213,731,200.58 | |
| **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН** | **437,991,709.97** | **135,248,000.00** | **329,817,969.74** | **194,569,969.74** | 243.9 |
| **ТАТВАР** | - | - | - | - | |
| **ТАТВАРЫН ДАРААХ АШИГ** | **635,490,107.03** | **0.00** | **476,421,893.26** | **476,421,893.26** | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Мөн аудитаар нийт 172,136.2 мянган төгрөгийн зөрчил[1]-д 9,627.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 162,509.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн санхүүгийн аудитын асуудлаарх зөрчил 9,627.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,598.3 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын удирдлага нь дээд шатны захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулсан ба гэрээг дүгнээгүй байхад хагас, бүтэн жилээр 150 хувийн урамшуулал 2,454.0 мянган төгрөгийг олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4.2-т “Гэрээний үүргийн биелэлтийг харгалзан тодорхой хэмжээний мөнгөн шагнал олгох”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
2. Нягтлан бодогчид орон нутгийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл нийт 7,173.0 мянган төгрөгийг олгосон нь 57.17-д "Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно", Засгийн газрын 2024.02.28-ны 82 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журмын 2.2-т "Орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцох үндсэн цалингийн хэмжээг тодорхойлохдоо МУ-ын ЗГ-ын тогтоолоор баталсан төрийн захиргааны болон төрийн улс төрийн албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг баримтална", Аймгийн Засаг даргатай 2025.01.23 -ны 01 дүгээр гэрээ байгуулсны 5.1.10 " Төвийн дарга нь төсөв санхүүгийн холбогдох хууль, дүрэм, журмыг чанд сахиж, санхүү хөрөнгийг оновчтой,зарцуулж, хамт олон иргэдэд нээлттэй мэдээлэх"- гэснийг тус тус хэрэгжүүлээгүй байна.

### 5.2 Зөвлөмж

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### *1. Эзэмшигчийн өмчтэй холбоотой асуудал*

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс 162,509.2 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 болон 13.1 дэх заалтыг баримтлан, улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүнгээр санхүүгийн тайлан дахь өмчийн дүнг залруулах ажлыг зохион байгуулж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Байгууллагын удирдлага нь дээд шатны захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулсан ба гэрээг дүгнээгүй байхад хагас, бүтэн жилээр 150 хувийн урамшуулал 2,454.0 мянган төгрөгийг олгосон | 1 | 2,454.0 | 1 | 2,454.0 | | | | | | | | |
| Нягтлан бодогчид орон нутгийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл нийт 7,173.0 мянган төгрөгийг олгосон | 1 | 7,173.0 | 1 | 7,173.0 | | | | | | | | |
| Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн | 1 | 162,509.2 | | | | | 1 | 162,509.2 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **3** | **172,136.2** | **2** | **9,6270.0** | | | **1** | **162,509.2** | **-** | **-** | **-** | **-** |